

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Галт сумын эрүүл мэндийн төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан**

Аудитын код: ХӨА-2026/050/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: Munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.09.25 № 01/168

танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЛТ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ О. ПҮРЭВЖАВ
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Галт сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Галт сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 73,180.6 мянган төгрөгийг санхүүжилтийн авлагатай, орон нутгийн төсөвт хийсэн хасах тодотголоос шалтгаалан 19,326.9 мянган төгрөгийн тогтмол зардлын өр төлбөртэй байна.

Аудитын гол асуудал

Аудитаар нийт 82,170.7 мянган төгрөгийн 17 алдаа, зөрчлийг илрүүлж мянган 59,800.2 мянган төгрөгийн 13 алдааг залруулж, 22,370.5 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Галт сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 94.3 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	183,601,244.21	223,465,542.69
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,654,603.68	7,312,982.07
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,654,603.68	7,312,982.07
3121	Төгрөг	9,654,603.68	7,312,982.07
31211	Төрийн сангийн харилцах	9,654,603.68	7,312,982.07
33	АВЛАГА	87,731,548.15	73,180,591.93
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	87,581,548.15	73,180,591.93
33300	Татаас, санхүүжилтийн авлага	150,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	86,215,092.38	142,971,968.69
351	Түүхий эд материал	21,834,730.03	44,066,306.44
35130	Эм боох материал	21,834,730.03	44,066,306.44
354	Хангамжийн материал	64,380,362.35	98,905,662.25
35410	Бичиг хэргийн материал	1,307,400.00	2,063,740.00
35420	Аж ахуйн материал	49,552,835.61	57,298,135.61
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	1,540,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,417,000.00	4,792,140.00
35450	Барилгын засварын материал	00.00	498,600.00
35460	Хүнсний материал	1,834,910.50	3,712,830.40
35470	Бусад хангамжийн материал	10,268,216.24	29,000,216.24
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,070,346,283.87	1,078,395,992.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,070,346,283.87	1,078,395,992.59
392	Биет хөрөнгө	1,048,744,283.87	1,056,793,992.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	988,629,914.43	988,629,914.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	-147,066,274.05	-173,261,892.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	92,196,100.00	58,796,100.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,566,430.17	-12,515,942.73
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	227,703,195.12	271,945,887.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	-80,199,222.76	-94,783,104.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,884,712.00	41,745,712.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,098,473.08	-23,804,481.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	808,382.20	808,382.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-589,419.82	-808,382.20
39217	Ном	41,800.00	41,800.00
393	Биет бус хөрөнгө	21,602,000.00	21,602,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,602,000.00	21,602,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,253,947,528.08	1,301,861,535.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,302,700.00	19,326,861.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,302,700.00	19,326,861.00
413	Өглөг	6,302,700.00	19,326,861.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,600,700.00	19,326,861.00
4136	Бусад өглөг	702,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	702,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,247,644,828.08	1,282,534,674.28
51	Засгийн газрын хувь оролцоо	1,247,644,828.08	1,282,534,674.28
511	/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	378,942,809.45	378,942,809.45
51101	Өмч: - төрийн	378,942,809.45	378,942,809.45
512	Хуримтлагдсан үр дүн	441,861,987.80	476,751,834.00
51210	Өмнөх үеийн үр дүн	441,861,987.80	441,711,987.80
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	35,039,846.20

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	426,840,030.83	426,840,030.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,253,947,528.08	1,301,861,535.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,748,861,855.71	1,896,794,714.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	281,022,292.73	195,417,223.87
120	Нийтлэг татварын бус орлого	281,022,292.73	191,278,223.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	281,022,292.73	191,278,223.87
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	82,970,000.00	116,262,393.22
1200017	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-үндсэн хөрөнгө	165,213,785.40	54,547,522.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	32,838,507.33	20,468,308.65
122	Тусламжийн орлого	00.00	4,139,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	4,139,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,467,839,562.98	1,701,377,490.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,665,700.00	52,964,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,665,700.00	52,964,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,406,173,862.98	1,648,413,390.90
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,406,173,862.98	1,648,413,390.90
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,567,661,173.40	1,860,695,800.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,567,661,173.40	1,860,695,800.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,516,720,873.40	1,750,811,403.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,049,501,353.48	1,246,658,981.80
210101	Үндсэн цалин	613,204,144.98	699,410,142.00
210102	Нэмэгдэл	343,837,308.50	398,447,849.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,204,000.00	40,975,000.00
210104	Урамшуулал	66,255,900.00	107,825,990.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,739,115.85	153,594,332.62
210201	Тэтгэврийн даатгал	88,330,202.41	104,238,480.37
210202	Тэтгэмжийн даатгал	10,495,178.91	12,463,699.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,088,528.39	7,615,700.68
210204	Ажилгүйдлийн даатгал	5,142,779.03	5,834,639.07
210205	Эрүүл мэндийн даатгал	20,682,427.11	23,441,812.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,324,400.00	69,774,821.00
210301	Гэрэл, цахилгаан	4,923,324.87	7,629,001.00
210302	Түлш, халаалт	49,788,275.13	60,533,020.00
210303	Цэвэр, бохир ус	1,612,800.00	1,612,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,883,420.00	50,921,035.00
210401	Бичиг хэрэг	2,344,400.00	7,295,740.00
210402	Тээвэр, шатахуун	33,908,720.00	31,803,695.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	969,500.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,700,000.00	2,814,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,960,800.00	9,007,100.00
2105	Нормативт зардал	140,897,326.44	134,442,345.54
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	127,631,298.94	115,548,425.44
210502	Хоол, хүнс	13,266,027.50	18,893,920.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,666,900.00	18,671,200.00
210604	Урсгал засвар	6,666,900.00	18,671,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,563,000.00	4,200,000.00

210702	Дотоод албан томилолт	1,563,000.00	4,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,788,642.00	5,511,942.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	948,500.00	4,858,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	99,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	8,800.00	27,800.00
210807	Газрын төлбөр	76,842.00	76,842.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	302,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,356,715.63	67,036,745.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,299,360.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,057,355.63	67,036,745.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,940,300.00	109,884,397.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,940,000.00	109,884,397.33
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	31,848,397.33
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,940,000.00	78,036,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	300.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	300.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>181,200,682.31</u>	<u>36,098,913.84</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	91,666,666.65	1,059,067.64
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,059,067.64
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	91,666,666.65	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-91,666,666.65	-1,059,067.64
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>89,534,015.66</u>	<u>35,039,846.20</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,489,100,878.83</u>	<u>1,832,040,840.34</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	82,970,000.00	116,262,393.22
120	Нийтлэг татварын бус орлого	82,970,000.00	116,262,393.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,970,000.00	116,262,393.22
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	82,970,000.00	116,262,393.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,406,130,878.83	1,715,778,447.12
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,665,700.00	52,964,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,665,700.00	52,964,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,344,465,178.83	1,662,814,347.12
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,344,465,178.83	1,662,814,347.12
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,449,932,741.33</u>	<u>1,816,923,461.95</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,449,932,741.33	1,816,923,461.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,398,992,441.33	1,707,039,064.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,045,417,360.90	1,245,875,182.12
210101	Үндсэн цалин	604,024,065.95	712,948,916.10
210102	Нэмэгдэл	362,407,526.95	391,369,277.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,489,270.00	39,817,331.00
210104	Урамшуулал	55,496,498.00	101,739,658.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	134,823,108.43	154,378,132.30

	ШИМТГЭЛ		
210201	Тэтгэврийн даатгал	90,955,508.43	103,189,075.79
210202	Тэтгэмжийн даатгал	10,966,900.00	12,763,249.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,483,500.00	7,126,071.44
210204	Ажилгүйдлийн даатгал	5,483,500.00	6,259,967.15
210205	Эрүүл мэндийн даатгал	21,933,700.00	25,039,768.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,865,400.00	50,823,100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,923,324.87	7,169,121.00
210302	Түлш, халаалт	49,329,275.13	42,175,579.00
210303	Цэвэр, бохир ус	1,612,800.00	1,478,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,259,020.00	48,615,775.00
210401	Бичиг хэрэг	2,538,900.00	3,878,380.00
210402	Тээвэр, шатахуун	32,272,820.00	34,803,695.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,700,000.00	2,814,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	969,500.00	956,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,777,800.00	6,162,700.00
2105	Нормативт зардал	97,524,650.00	152,373,723.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,469,440.00	118,553,883.20
210502	Хоол, хүнс	13,055,210.00	15,087,840.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	18,732,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,689,900.00	25,798,010.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	981,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	4,358,510.00
210604	Урсгал засвар	8,689,900.00	20,458,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,563,000.00	4,200,000.00
210702	Дотоод албан томилолт	1,563,000.00	4,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,486,642.00	7,053,642.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,348,500.00	4,858,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	99,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	8,800.00	27,800.00
210807	Газрын төлбөр	76,842.00	76,842.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	302,500.00	839,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,363,360.00	17,921,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,363,360.00	17,921,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,940,300.00	109,884,397.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,940,000.00	109,884,397.33
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	31,848,397.33
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,940,000.00	78,036,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	39,168,137.50	15,117,378.39
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	33,700,000.00	17,459,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,700,000.00	17,459,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,700,000.00	17,459,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,700,000.00	17,459,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ	-33,700,000.00	-17,459,000.00

	ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,468,137.50	-2,341,621.61
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,186,466.18	9,654,603.68
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,654,603.68	7,312,982.07

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	378,942,809.45	426,840,030.83	352,327,972.14	1,158,110,812.42
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	89,534,015.66	89,534,015.66
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	378,942,809.45	426,840,030.83	441,861,987.80	1,247,644,828.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-150,000.00	-150,000.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	3,492,324.20	3,492,324.20
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	378,942,809.45	426,840,030.83	445,204,312.00	1,250,987,152.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,919,578,000.00	1,779,076,740.34	92.68	140,501,259.66
12	Татварын бус орлого	1,919,578,000.00	1,779,076,740.34	92.68	140,501,259.66
120	Нийтлэг татварын бус орлого	124,676,100.00	116,262,393.22	93.25	8,413,706.78
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	124,676,100.00	116,262,393.22	93.25	8,413,706.78
122	Тусламжийн орлого	1,794,901,900.00	1,662,814,347.12	92.64	132,087,552.88
122001	Хандив тусламж /дотоод/	1,794,901,900.00	1,662,814,347.12	92.64	132,087,552.88
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,929,111,600.00	1,781,418,361.95	92.34	147,693,238.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,929,111,600.00	1,781,418,361.95	92.34	147,693,238.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,804,887,600.00	1,671,533,964.62	92.61	133,353,635.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,308,055,700.00	1,245,875,182.12	95.25	62,180,517.88
210101	Үндсэн цалин	775,768,900.00	712,948,916.10	91.90	62,819,983.90
210102	Нэмэгдэл	424,001,900.00	391,369,277.02	92.30	32,632,622.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	65,392,200.00	39,817,331.00	60.89	25,574,869.00
210104	Урамшуулал	42,892,700.00	101,739,658.00	237.20	(58,846,958.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,697,200.00	154,378,132.30	85.43	26,319,067.70
210201	Тэтгэврийн даатгал	123,510,900.00	103,189,075.79	83.55	20,321,824.21
210202	Тэтгэмжийн даатгал	14,296,500.00	12,763,249.58	89.28	1,533,250.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,148,300.00	7,126,071.44	99.69	22,228.56
210204	Ажилгүйдлийн даатгал	7,148,300.00	6,259,967.15	87.57	888,332.85
210205	Эрүүл мэндийн даатгал	28,593,200.00	25,039,768.34	87.57	3,553,431.66

2104	Хангамж, бараа материалын зардал	50,629,200.00	48,615,775.00	96.02	2,013,425.00
210401	Бичиг хэрэг	4,271,300.00	3,878,380.00	90.80	392,920.00
210402	Тээвэр, шатахуун	34,544,400.00	34,803,695.00	100.75	(259,295.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,728,700.00	2,814,500.00	103.14	(85,800.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,453,800.00	956,500.00	65.79	497,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,631,000.00	6,162,700.00	80.76	1,468,300.00
2105	Нормативт зардал	157,452,500.00	152,373,723.20	96.77	5,078,776.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	126,819,900.00	118,553,883.20	93.48	8,266,016.80
210502	Хоол, хүнс	11,632,600.00	15,087,840.00	129.70	(3,455,240.00)
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,000,000.00	18,732,000.00	98.59	268,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,299,100.00	41,116,010.00	78.62	11,183,090.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,222,300.00	3,760,200.00	60.43	2,462,100.00
210602	Тавилга	19,000,000.00	14,680,000.00	77.26	4,320,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	4,358,510.00	87.17	641,490.00
210604	Урсгал засвар	22,076,800.00	18,317,300.00	82.97	3,759,500.00
2107	Томилолт, зочны зардал	4,575,000.00	4,200,000.00	91.80	375,000.00
210702	Дотоод албан томилолт	4,575,000.00	4,200,000.00	91.80	375,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,754,800.00	7,053,642.00	22.94	23,701,158.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,177,800.00	4,858,300.00	17.24	23,319,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00	100.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	-	-	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	99,000.00	99.00	1,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,300.00	27,800.00	78.75	7,500.00
210807	Газрын төлбөр	250,000.00	76,842.00	30.74	173,158.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	839,700.00	839,700.00	100.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,424,100.00	17,921,500.00	87.75	2,502,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,424,100.00	17,921,500.00	87.75	2,502,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,224,000.00	109,884,397.33	88.46	14,339,602.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,224,000.00	109,884,397.33	88.46	14,339,602.67
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,188,000.00	31,848,397.33	68.95	14,339,602.67
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	78,036,000.00	78,036,000.00	100.00	-
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(9,533,600.00)	(2,341,621.61)		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,533,600.00	2,341,621.61		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	9,533,600.00	2,341,621.61		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,654,603.68		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,312,982.07		

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	53,098,800.00	52,964,100.00	99.75	134,700.00
12	Татварын бус орлого	53,098,800.00	52,964,100.00	99.75	134,700.00
122	Тусламжийн орлого	53,098,800.00	52,964,100.00	99.75	134,700.00
122005	Төсвөөс санхүүжих	53,098,800.00	52,964,100.00	99.75	134,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,098,800.00	52,964,100.00	99.75	134,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,098,800.00	52,964,100.00	99.75	134,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,098,800.00	52,964,100.00	99.75	134,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,911,900.00	50,823,100.00	99.83	88,800.00
210301	Гэрэл, цахилгаан	7,788,600.00	7,169,121.00	92.05	619,479.00
210302	Түлш, халаалт	41,510,200.00	42,175,579.00	101.60	(665,379.00)
210303	Цэвэр, бохир ус	1,613,100.00	1,478,400.00	91.65	134,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зар	2,186,900.00	2,141,000.00	97.90	45,900.00
210604	Урсгал засвар	2,186,900.00	2,141,000.00	97.90	45,900.00
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-		

3.. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 82,170.7 мянган төгрөгийн 17 алдаа, зөрчлийг илрүүлснээс мянган 59,800.2 мянган төгрөгийн 11 алдааг залруулж, 22,370.5 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч, нийцлийн аудитаар илрүүлсэн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Залруулсан алдаа

Аудитын явцад илэрсэн дараах алдааг залруулсан. Үүнд:

1. Тайлант жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3 дугаар зүйлд заасан “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;” заалттай нийцэхгүй, “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад нөхөж ирүүлэн, алдааг залруулсан.
2. Төсвийн гүйцэтгэлийн тайланг 9,533.6 мянган төгрөгөөр зөрүүтэй бэлтгэсэн, Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан загвараар бэлтгэж ирүүлээгүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад алдааг засаж, маягтын дагуу бэлтгэж ирүүлсэн.
3. Хөдөлмөр хамгааллын зардлаас гарсан 4,358.5 мянган төгрөгийн гүйлгээг эмийн зардлаар бүртгэсэн, томилолтын зардлыг 80.0 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.
4. Ажиллагсад томилолт 100.0 мянган төгрөг, хоолны хөнгөлөлт 15.0 мянган төгрөгөөр илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад байгууллагын дансанд тушааж залруулсан.

5. ЭМДС-ийн санхүүжилтийг 26,295.9 мянган төгрөг, өөрийн орлогыг 70.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгаснаас үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг буруу дүнгээр толилуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.
6. Бараа материалын тодруулга санхүүгийн тайлангийн толилуулгаас 285.7 мянган төгрөгөөр зөрүүтэй бэлтгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.
7. Нийгмийн эрүүл мэндийн зардлаас гаргасан 17,521.5 мянган төгрөгийн гүйлгээг үр дүнгийн тайланд холбогдох зардлуудад бүртгээгүй, бусад зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.
8. Автомашины дугуй, аккумулятор гэсэн ашиглалтын норм бүхий 1,540.0 мянган төгрөгийн хөрөнгийг шууд тайлант үеийн зардлаар бүртгэж зарлагадсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 22,370.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 25,160.6 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

2.2.Албан шаардлага

1. Шилэн дансны цахим хуудсанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийг хугацаа хоцроож мэдээлсэн. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”, 6 дугаар зүйлийн 6.4.4 “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;” гэж заасан заалттай нийцэхгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байгаа нь “нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд зөрчил таслан зогсоох тухай албан шаардлагыг хүргүүлсэн.
2. Галт сумын эрүүл мэндийн төв нь 2025 онд цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой 29,955.8 мянган төгрөгийн эмийг шууд худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна.” заалттай нийцэхгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

2.3.Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж 16,532.7 мянган төгрөгийн гүйлгээг хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулах

Илрүүлэлт 2:

Галт сумын ИТХ-ын 2025 оны 12 сарын 19-ний өдрийн хуралдааны 24 дүгээр тогтоолоор 73 ширхэг 61,825.8 мянган төгрөгийн анхны өртөг бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, “тэг” үлдэгдэлтэй үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнэлгээг шинэчлэн тогтоохоор шийдвэрлэсэн боловч тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бичилтийг хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын ИТХ-ын хурлын шийдвэрийг нягтлан бодох бүртгэлд тусгах

Илрүүлэлт 3:

Төлбөртэй үйлчилгээний орлого 5,837.8 мянган төгрөгийг Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.6.10 заалтад заасан “Төсвийн байгууллага нь мөнгөн касстаа бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана;” заалтыг хэрэгжүүлээгүй байгаа нь “үнэлгээ ба батламж” мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Төлбөртэй үйлчилгээний орлогыг тухай бүрд нь байгууллагын харилцах дансанд төвлөрүүлэх

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг

журам"-ийн дагуу 2025 онд хэрэгжүүлэх дотоод хяналтын ажлын төлөвлөгөөнд 10 ажлыг хийхээр төлөвлөснөөс 9 ажлыг хэрэгжүүлж, 81 хувийн биелэлттэй тайлагнасан гэсэн боловч дотоод хяналтыг баримтжуулж, тайлагнаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Байгууллагын удирдлагын зүгээс дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг тооцох

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруу лаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэн бүрэлдэхүүнээр, батлагдсан маягтаар бэлтгээгүй.	1	-	1	-			1	-		
Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй бэлтгэсэн	1	9,533.6			1	9,533.6	1	9,533.6		
Зардлыг буруу дансаар бүртгэсэн.	1	4,438.5			1	4,438.5	1	4,438.5		
Томилолт хоолны мөнгийг илүү олгосон	1	115.0			1	115.0	1	115.0		
Орлогыг зөрүүтэй дүнгээр бүртгэсэн	1	26,365.9			1	26,365.9	1	26,365.9		
Санхүүгийн тайланд толилуулсан бараа материалын дүн тодруулгаас зөрүүтэй	1	285.7			1	285.7	1	285.7		
Үр дүнгийн тайланд бараа материалыг зарлагдахдаа эдийн засгийн ангилал буруу сонгосон	1	17,521.5			1	17,521.5	1	17,521.5		
Автомашин дугуй, аккумуляторыг ашиглалтад тавьж олгохдоо шууд зарлагад бичсэн	1	1,540.0								
Дүн	8	59,800.2	1	-	7	59,800.2	8	59,800.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шүдний төлбөртэй үйлчилгээний орлогыг тухай бүрт нь дансанд тушаагаагүй	1	5,837.8					1	5,837.8
Төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээг хийсэн	1	16,532.7					1	16,532.7

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн "0" үлдэгдэлтэй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнэлгээг шинэчлээгүй	1	-					1	-
Дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаагүй	1	-					1	-
Дүн	4	22,370.5					4	22,370.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд 11 нэр төрлийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	-			1	-		
Цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой эмийг шууд худалдаж авсан.	1	-			1	-		
Дүн	2	-			2	-		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			